



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар A/98

Жаргалтхаан


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны A/348 дугаар захирамж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 103 жил, Жаргалтхаан сум үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулахад зориулж 15,000,000 (арван таван сая) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх зардалд зарцуулагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын төсвийн Улсын их баяр наадмын зардлаас гаргаж тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Э.Загдхүү нарт зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (С.Ганбат)-д даалгасугай.

ДАРГА

Л.ЦЭНГЭЛ



Data (D:) /A4 zahiramj/

232401237